



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төв аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

Аудитын код: ТӨА-2025/002/НА-СТА-ЗГТС

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер О.Амаржаргал Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор Ц.Саранчимэг Утас: 70273465 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Ихмонгол хөлөг Аудит" ХХК Утас: 99061771 Цахим хаяг: info@imkaudit.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582. Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

АДДС. 02.25 № 01/187
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Нийгмийн даатгалын сан нь 2024 оны санхүүгийн тайланг тайлагнахдаа ажил олгогч болон даатгуулагчийн ЭМД, НДШ-ийн нийт авлагаас ЭМД-ын шимтгэлийн авлагыг нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр хасаж, санхүүгийн авлагын үлдэгдлийг цэвэр дүнгээр тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс нийгмийн даатгалын ерөнхий хуулийг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотойгоор тэтгэвэр, тэтгэмж тогтоох, ажил олгогчид үзүүлэх хөнгөлөлт болон бусад шинээр баталсан эрх зүйн актуудыг мөрдүүлэх, мэдээллийн нэгдсэн программ хангамж нэвтрүүлэх зэрэг бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ. Нийгмийн даатгалын тогтолцоо 1995 онд бий болсноос хойших хугацаанд улсын хэмжээнд 21 аймаг, 9 дүүрэг бүрд мэдээллийн системийн тусдаа сервертэй, бүтээгдэхүүн, үйлчилгээ бүрд ашиглагдаж байсан 60-аад төрлийн программ хангамжийг нэгдсэн шинэ систем (SICOS)-д хөрвүүлэх, бүртгэх, нэгтгэх үйл явцад даатгуулагчийн давхардсан болон зөрүүтэй мэдээллийг нягтлах, завсарлах, тэтгэвэр авагчдын тэтгэврийн тогтоолт, өөрчлөлтийн мэдээллийг программд оруулах, хуваарь, нэхэмжлэх, олголт үүсгэх, зарлагын тооцоог хаах зэрэг үйлдлийг

412502208

тайлант хугацаанд бүрэн хийж дуусгаагүйгээс, санхүүгийн тайланг хуулийн хугацаанд тайлагнаагүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	20,360,517,801.51	16,420,543,007.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	15,337,928,129.69	12,613,147,691.13
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	15,337,928,129.69	12,613,147,691.13
31210	Төгрөг	15,337,928,129.69	12,613,147,691.13
31211	Төрийн сангийн харилцах	577,478,915.37	-
31213	Арилжааны банк дахь харилцах	14,760,449,214.32	12,613,147,691.13
33	АВЛАГА	5,022,589,671.82	3,807,395,316.37
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	3,112,450,464.39	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,431,179,494.48	1,417,967,588.48
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	-	1,771,252,219.37
33500	Бусад авлага	478,959,712.95	618,175,508.52
33510	Байгууллагаас авах авлага	478,959,712.95	355,291,080.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	-	262,884,428.52
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	20,360,517,801.51	16,420,543,007.50
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,227,307,591.11	2,300,827,642.62
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,227,307,591.11	2,300,827,642.62
41300	Өглөг	461,733,597.47	1,095,415,948.07
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	461,733,597.47	-
41360	Бусад өглөг	-	1,095,415,948.07
41361	Байгууллагад төлөх өглөг	-	233,470,299.07
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	859,676,335.94
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	-	2,269,313.06
41400	Урьдчилж орсон орлого	765,573,993.64	1,205,411,694.55
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	765,573,993.64	1,205,411,694.55
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	19,133,210,210.40	14,119,715,364.88
51	Засгийн газрын хувь оролцоо	19,133,210,210.40	14,119,715,364.88
51200	Хуримтлагдсан үр дүн	19,133,210,210.40	14,119,715,364.88
51210	Өмнөх үеийн үр дүн	15,994,249,823.60	18,647,875,700.63
51220	Тайлант үеийн үр дүн	3,138,960,386.80	-4,528,160,335.75
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	20,360,517,801.51	16,420,543,007.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	254,962,497,877.66	205,535,063,397.59
11	ТАТВАРЫН ОРЛОГО	51,884,910,766.97	56,393,893,631.25
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	51,884,910,766.97	56,393,893,631.25
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	35,748,029,669.06	47,148,002,881.84
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,738,729,394.95	5,002,792,269.23
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,725,095,280.60	2,593,269,639.73
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	706,434,254.34	1,649,828,840.45
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	8,966,622,168.02	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	141,504,846.09	148,082,065.88
120	Нийтлэг татварын бус орлого	141,504,846.09	148,082,065.88
120002	Хүүгийн орлого	76,884,325.34	133,759,408.86
120003	Торгуулийн орлого	-	208,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	43,662,949.75	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	43,662,949.75	-
120009	Бусад орлого	20,957,571.00	14,114,157.02
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	202,936,082,264.60	148,993,087,700.46
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	14,850,574,119.00	30,823,261,907.46
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	14,850,574,119.00	30,823,261,907.46
1330	Төсвийн захирагчдаас	188,085,508,145.60	118,169,825,793.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	188,085,508,145.60	118,169,825,793.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	251,823,537,490.86	210,063,223,733.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	251,823,537,490.86	210,063,223,733.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,325,790.00	16,880,030.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,325,790.00	16,880,030.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	7,120,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	9,325,790.00	9,760,030.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	251,814,211,700.86	210,046,343,703.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	121,154,804,101.00	153,971,044,759.10
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	121,154,804,101.00	153,971,044,759.10
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	130,659,407,599.86	56,075,298,944.24
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	130,659,407,599.86	56,075,298,944.24
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,138,960,386.80	(4,528,160,335.75)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	3,138,960,386.80	(4,528,160,335.75)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	256,575,522,064.74	217,956,189,865.99
11	ТАТВАРЫН ОРЛОГО	50,884,927,777.27	69,193,390,331.03
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	50,884,927,777.27	69,193,390,331.03
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	35,087,367,260.05	48,197,590,011.49
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,665,006,820.16	5,015,380,213.79
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,668,399,786.36	3,959,338,631.72
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	690,142,452.65	1,733,011,594.33
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	8,774,011,458.05	10,288,069,879.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	242,224,041.87	170,598,341.96
120	Нийтлэг татварын бус орлого	242,224,041.87	170,598,341.96
120002	Хүүгийн орлого	52,429,882.84	134,257,703.45
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	189,794,159.03	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	189,794,159.03	-
120009	Бусад орлого	-	36,340,638.51
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	205,448,370,245.60	148,592,201,193.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	17,362,862,100.00	30,422,375,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	17,362,862,100.00	30,422,375,400.00
1330	Төсвийн захирагчдаас	188,085,508,145.60	118,169,825,793.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	188,085,508,145.60	118,169,825,793.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	251,995,932,154.17	220,680,970,304.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	251,995,932,154.17	220,680,970,304.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,325,790.00	87,252,665.36
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,325,790.00	16,880,030.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	7,120,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	9,325,790.00	9,760,030.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	70,372,635.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	70,372,635.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	251,986,606,364.17	220,593,717,639.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	121,327,198,764.31	153,410,301,147.51
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	121,102,132,495.00	153,410,301,147.51
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	225,066,269.31	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	130,659,407,599.86	67,183,416,491.68
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	130,659,407,599.86	67,183,416,491.68
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,579,589,910.57	(2,724,780,438.56)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	4,579,589,910.57	(2,724,780,438.56)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,758,338,219.12	15,337,928,129.69
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,337,928,129.69	12,613,147,691.13

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	15,992,975,434.61	15,992,975,434.61
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,274,388.99	1,274,388.99
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	15,994,249,823.60	15,994,249,823.60
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	3,138,960,386.80	3,138,960,386.80
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	19,133,210,210.40	19,133,210,210.40
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-485,334,509.77	-485,334,509.77
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	18,647,875,700.63	18,647,875,700.63
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	-4,528,160,335.75	-4,528,160,335.75
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	14,119,715,364.88	14,119,715,364.88

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	157,019,134,000.00	153,427,181,177.51	-3,591,952,822.49	97.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	157,019,134,000.00	153,427,181,177.51	-3,591,952,822.49	97.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,084,100.00	16,880,030.00	-3,204,070.00	84.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,084,100.00	16,880,030.00	-3,204,070.00	84.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,903,300.00	7,120,000.00	-1,783,300.00	80.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	11,180,800.00	9,760,030.00	-1,420,770.00	87.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	156,999,049,900.00	153,410,301,147.51	-3,588,748,752.49	97.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	156,999,049,900.00	153,410,301,147.51	-3,588,748,752.49	97.7
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	156,999,049,900.00	153,410,301,147.51	-3,588,748,752.49	97.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	157,019,134,000.00	89,468,480,456.78	-67,550,653,543.22	57.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	30,422,375,400.00	30,422,375,400.00	-	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	30,422,375,400.00	30,422,375,400.00	-	100.0
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	126,596,758,600.00	59,046,105,056.78	-58,904,667,865.76	46.7
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	126,596,758,600.00	59,046,105,056.78	-58,904,667,865.76	46.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	15,337,928,129.69		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	12,613,147,691.13		

3. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

3.1 Аудитаар нийт 170,921,328.9 мянган төгрөгийн 6 алдаа¹ илэрснээс аудитын явцад 170,921,328.9 мянган төгрөгийн 6 алдааг залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн үр дүнгийн тайланд тайлагнасан нийт үр дүн, санхүүгийн байдлын тайлангийн өр төлбөр цэвэр өмчид тайлагнасан дүнгээс 1,733,329.9 мянган төгрөгөөр зөрүүтэй буюу өр төлбөр цэвэр өмчийн дүн, нийт хөрөнгийн дүнгээс 1,733,329.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан.	1	1,733,329.9			1	1,733,329.9	1	1,733,329.9				
Зээлийн хүүгийн авлага 98,688.2 мянган төгрөгийг бүртгэж тайлагнасан байна.	1	98,688.2			1	98,688.2	1	98,688.2				
Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 31,925.7 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна	1	31,925,689.6	1	31,925,689.6			1	31,925,689.6				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд 62,545.2 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийн тохируулгыг хийгээгүйгээс төсвийн гүйцэтгэлийн тайлан зөрүүтэй тайлагнагдсан.	1	62,545,234.3			1	62,545,234.3	1	62,545,234.3				
Мөнгөн гүйлгээний тайлангийн нийт цэвэр мөнгөн гүйлгээ 12,457.9 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	12,457,910.2			1	12,457,910.2	1	12,457,910.2				
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн үр дүн 62,160.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан.	1	62,160,476.7			1	62,160,476.7	1	62,160,476.7				
Дүн	6	170,921,328.9	1	31,925,689.6	5	138,995,639.3	6	170,921,328.9	-	-	-	-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

3.2 Аудитаар нийт 1,587,384.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 1,586,906.7 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 477.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд 603,072.1 мянган төгрөгийн авлага, 311,483.3 мянган төгрөгийн өглөг, нийт 914,555.3 мянган төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдэлд тооцоо нийлж, тулган баталгаажаагүй байна.	1	914,555.3			1	914,555.3						
Шалгагдагч байгууллага нь тайлант оны нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг Санхүүгийн үр дүнгийн тайланд 477.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	1	477.7					1	477.7				
НДЕГ-ын даргын 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/240 дүгээр тушаалаар батлагдсан орлогын төлөвлөгөөнд, хуримтлагдсан авлагаас 1,764,181.8 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 1,215,194.3 мянган төгрөгийг барагдуулж 549,987.5 мянган төгрөгийн авлагыг дутуу төвлөрүүлсэн байна.	1	549,987.5			1	549,987.5						
Батлагдсан орлогын төлөвлөгөөний биелэлт 99.4 хувьтай буюу 122,363.9 мянган төгрөгөөр тасарсан байна.	1	122,363.9			1	122,363.9						
Дүн	4	1,587,384.4	0	-	3	1,586,906.7	1	477.7	-	-	-	-

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1 зөрчил илэрснээс, 1 албан зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Тайлант оны шилэн дансны цахим хуудсыг шалгахад нийт 159 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 146, хугацаа хоцорч мэдээлсэн 8, хүлээгдэж байгаа 5 мэдээлэл байна. Шилэн дансанд мэдээлсэн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээг Мөнгөн гүйлгээний журналын орлого, зарлагын дүнтэй тулгахад тохирч байна.	1	-			1	-
Дүн	1	-			1	-